СҮХБААТАР АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН АЖИЛЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨР

2021.10.10.

Нэг: Нийтлэг үндэслэл

Мэргэжлийн хяналтын газрын дотоод журмын хэрэгжилт нь нийт ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулан баталж хэрэгжүүлэх хууль эрх зүйн үндэслэл болно.

Мэргэжлийн хяналтын газрын нийт албан хаагчдын хүний нөөцийн хөгжил, чадавхыг сайжруулах, идэвх санаачилга, ажлын бүтээмжийг дээшлүүлэх, ажлын байрны тав тухтай орчныг бүрдүүлэх, гэр бүлийн сайн сайхан байдал, эвсэг бүтээлч, багаар ажиллах чадвартай, эрүүл чийрэг бие бялдартай, хүнлэг сэтгэлтэй, ёс зүйтэй хамт олныг төлөвшүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Хоёр: Хэрэгцээ, шаардлага /Хугацаа 4 жил/

Мэргэжлийн хяналтын газрын ажилтан ажилчдын 75% нь залуу гэр бүл бөгөөд цалингаас өөр орлогогүй, бага насны хүүхдүүдтэй байна. Үлдсэн 25% нь -аас дээш насныхан боловч оюутны төлбөрийн дарамттай, цалингийн зээлтэй, авч байгаа цалин нь бараа бүтээгдэхүүний үнийн өсөлттэй уялдахгүй байгааг харгалзан төрийн байгууллагын зүгээс дэмжлэг зайлшгүй шаардлагатай байна.

Иймд тэдний амьдрал ахуйг өөд татах ямар нөөц боломж байгааг эрэлхийлэх, тодорхой үр дүнтэй ажлуудыг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага байна.

2.1. Хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

2.1.1. Мэдлэг боловсролыг нь дээшлүүлэн, хувь хүний хөгжлийг нь хангах.

2.1.2. Эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэхэд нь дэмжлэг үзүүлэх.

2.1.3. Ажлын байрны хэвийн таатай орчныг бүрдүүлэх.

2.1.4. Амьдралын нөхцөлөө сайжруулж, гэр бүлийн харилцаанд нь эерэг нөлөө үзүүлэх.

Гурав: Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Мэдлэг боловсролыг нь дээшлүүлэн, хувь хүний хөгжлийг хангах зорилтын хүрээнд:

3.1.1. Ажлын байрнаас хөндийрөхгүйгээр мэргэжил мэдлэгээ дээшлүүлэх, давтан сургалтад хамрагдах нөхцөл боломжоор хангах.

3.1.2. Магистр, докторын сургалтад хамрагдахад цалинтай чөлөө олгох.

3.1.3. Хувь хүний хөгжлийн сургалтуудад тодорхой давтамжтайгаар хамруулан чадвахжуулна.

3.1.4. Хамт олноороо хөгжих сургалтын зардлыг хариуцах.

3.1.5. “Гэр бүлийн хөгжил, боловсрол” олгох сургалтыг ажилтан ажилчдын гэр бүлд зориулан тусгай төлөвлөгөөтэй хийх.

3.2. Эрүүл мэндээ хамгаалах, урьдчилан сэргийлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд:

3.2.1. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд 2 удаа хамруулж оношилгоо хийлгэж, эмчилгээ үйлчилгээ авахад нь 1 удаа санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

3.2.2. Ажлын байрны дасгал хөдөлгөөн хийлгэх замаар хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх.

3.2.3. Жилд 2 удаа амин дэмээр хангах үйлчилгээ үзүүлэх.

3.2.4. Эрүүл мэндийн зохих боловсролтой болгох сургалтыг улирал бүр зохион байгуулах.

3.2.5. Гэр бүлийн гишүүдийнх нь эрүүл мэндэд анхаарал хандуулж ажиллах.

3.3. Ажлын байрны хэвийн таатай орчныг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

3.3.1. Ажлын байр бүрд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах.

3.3.2. Ажил үйлчилгээ үзүүлэхэд тохиромжтой, нууцлалыг хадгалах боломжтой өрөө тасалгаагаар хангах.

3.3.3. Ажлын байранд амрах боломжтой өрөө тасалгаа тохижуулсан байх.

3.3.4. Хүүхэд тоглох, хичээл давтах боломжтой өрөөгөөр хангах.

3.3.5. Ажлын байрны ХАБЭА-н шаардлагыг бүрэн хангах

3.4. Амьдралын нөхцөлөө сайжруулах, гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

3.4.1. Хөнгөлөлттэй зээл, тусламжид хамрагдахад баталгаа гаргаж өгөх.

3.4.2. Орон байрны нөхцөлөө сайжруулахад нь дэмжлэг үзүүлэх.

3.4.3. Өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломжит их үүсвэрийг бий болгох.

3.4.4. Гэр бүлийнх нь гишүүдийг ажилтай орлоготой болоход нь дэмжлэг үзүүлэх.

3.4.5. Гэр бүлээрээ аялах аяллыг хамт олноороо зохион байгуулах.

3.4.6. Хувийн аж ахуй эрхлэх боломжоор хангах

3.4.7. Ажилчдад төсвийн боломжтой нөхцөлийг харгалзан унаа, хоолны зардал, ажлын үр дүнгийн урамшуулал нэмэгдлүүдийг олгох.

3.4.8. Хувийн хэрэгцээний өмчлөлийн болон эзэмшлийн газартай болоход нь дэмжлэг үзүүлэх.

3.4.9. Галлагаатай байранд амьдардаг албан хаагчдад түлээ нүүрсний дэмжлэг үзүүлэх.

Дөрөв: Хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрсэн байна.

4.1.1. Нийт ажилчдын 75% нь мэргэжил ур чадвар ахиулах сургалтад хамрагдсан байна.

4.1.2. Мэргэжилтнүүдийн 2-оос доошгүй нь магистрын сургалтад хамрагдсан байна.

4.1.3. “Ажилчдын гэр бүлд зориулсан төлөвлөгөөт сургалт”-д гэр бүлээрээ оролцож ур чадвар, мэдлэгтэй болсон байна.

4.1.4. Хамт олноороо хөгжлийн сургалтад хамрагдсан байна.

4.1.5. Ажилтан, ажилчдыг гэр бүлийхэнтэй нь эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулсан байна.

4.1.6. Ажлын байрны нөхцөл сайжирч, техник хэрэгсэл тоног төхөөрөмжөөр хангасан байна.

4.1.7. Хамт олноороо 2-оос доошгүй удаа хөгжлийн сургалтад хамрагдсан байна.

4.1.8. Байгууллагын 1-2 ажилтан орон байрны нөхцөлөө сайжруулсан байна.

4.1.9. Ажилтан, ажилчдын 4-5 нь хүний хувийн аж ахуй эрхэлж өрхийн орлогоо нэмэгдүүлсэн байна.

4.1.10. Ажилчдын амрах, хүүхдийн тоглоомын өрөөтэй болсон байна.

Тав: Хөтөлбөрийн санхүүжилт

5.1. Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

5.1.1. Орон нутгийн төсөв

5.1.2 Хөнгөлөлттэй зээл, тусламж

5.1.3. Аж ахуй нэгж, байгууллага, хувь хүний дэмжлэг

5.1.4. Бусад эх үүсвэр